

10

АЖ АХУЙ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ-АУДИТЫН ҮР ХӨВРӨЛ

Л. Мөнх-очир.

Хяналт нийгмийн аль ч тогтолцоонд үйлчилж, мөн чанар нь нийгмийн харилцааны хөгжлөөр тодорхойлогдон, хөгжлийн шат бүрд өөрийн өвөрмөц онцлогтойгоор хөгжиж иржээ. Нийгэмд хяналтын олон төрөл, хэлбэр байдгаас санхүүгийн хяналт уг тогтолцоонд чухал байр эзэлдэг төдийгүй нийгмийн хөгжлийн явцад улам боловсронгуй болон өөрчлөгдөн хөгжсөөр байгаа эдийн засгийн дэд бүтцийн нэг гэж хэлж болно. Санхүүгийн хяналт хүний нийгмийн үүсэл, өмч бий болсон түүхтэй салшгүй холбоотой.

Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үүссэн түүхийг авч үзвэл хэмжлийн загвар ба хяналт чухам хэдийд үүсэж бий болсон, аль нь эхэлж үүссэн, бүртгэлийн үүслийг хэдий үеэс эхэлж тоолох нь зүйтэй вэ гэдэг талаар олон улс орны судлаачдын нижгээд таамаглал, санал байдаг тул чухам аль нь эрдэмтэдийн дунд давамгайлж байгаагаар өнөөдөр түүний үүслийг тогтоосон байдаг.

Мэдээллийн технологийн анхны хөврөл - данс бичилтийн хамгийн энгийн хэлбэр мэргэжлийн үйлчилгээ ба шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан хүрээ болтлоо хөгжсөн түүхийг бусад шинжлэх ухаануудтай зэрэгцүүлж үзвэл хүн төрлөхтний хөгжлийн түүхэнд нягтлан бодох бүртгэл хамгийн урт замыг туулсан ухаануудын нэг гэдэг нь ойлгомжтой юм.

Мэргэжлийн түүх судлаачид хүн төрлөхтөн үүсч, хамтын хүчээр хүнс тэжээлээ олж бэлтгэж эхэлсэн тэр үеэс санхүүгийн хэмжилт ба энгийн бичилт бүртгэл үүсэх хэрэгцээ нэгэнт бүрдсэн хэмээн үздэг. Тэдний үзэж байснаар аж ахуйн бүртгэл, тэр дундаа “агуулахын бүртгэл” мэргэжлийн үйлчилгээний эхлэлийг тавьсан ба тэр нь анхнаасаа хяналтын үүргийг гүйцэтгэж ирсэн. Хүмүүс нэгэнт бий болгосон зүйлсийг хэрэгцээндээ зарцуулахын тулд нөөцлөх, хадгалах, дахин олж авахын хэрээр нэмэгдэж бас хэрэглээний дагуу багасан хөдөлгөөнд орж, улмаар

түүнийг тоолох хэрэгцээ бий болж үлдэгдлийг омгийн ахлагч цээжээр тогтоодог байснаа хүмүүс олноор амьдрах болж хэрэглээ нэмэгдэхийн хэрээр цээжлэн тогоох аргагүй болж чулуу, мод, навчин дээр тэмдэглэдэг болсныг мэргэжлийн түүхэнд дэлгэрэнгүй өгүүдсэн байдаг³. Энэ бол мэдээллийн технологийн эхний шат байсан ба эртний хүмүүс өөрийн энэхүү хэрэглээг анх удаа мод, чулуу, навч, тусгайлан бэлтгэсэн шавар дээр тэмдэглэх болсноор санхүүгийн баримт буюу бичмэл мэдээлэл үүсэх эхлэл тавигджээ.

Харин данс бичилтийн арай илүү хөгжлийг бий болгосон газар бол эртний Египет, Грек, Рим юм. Эрдэмтэд, судлаачид эртний Египедийг нягтлан бодох бүртгэлийн энгийн бичилтийн өлгий нутаг гэж үздэг. Эдгээр оронд газар хагалж тариа тарих үйл ажиллагаа нь бүртгэлийн мэдээллийн хөгжилд түлхэц үзүүлсэн. Газар хэмжих, будаа тариа хадгалах, түүнийгээ хэмжин тоолох зэргээс агуулахын нэлээд боловсронгуй бүртгэл үүссэн.

Газар тариалан эрхлэгчийн хувьд хөдөлмөрийн үндсэн хэрэгсэл нь анжис, газар байсан бол зэрлэг амьтадыг гаршуулан тэжээдэг байснаа гэрийн болгон тэдгээрийг өөрсдийн хэрэгцээнд ашиглан ашиг шимийг нь хүртэж, тэр нь аж ахуйн шинжийг олж малыг улмаар өмчлөх болсон үед овгуудын эртнээс хэрэглэж ирсэн бэлэг тэмдгийг илэрхийлсэн төрөл бүрийн дүрсээр малыг тамгалах болсон нь нэг талаар өөрийн өмчлөлийг тогоосон хэрэг, нөгөө талаар энэ нь бүртгэл, хяналт байжээ гэж үзэж болох юм.

Манай нэрт судлаач, эрдэмтэн Х.Пэрлээ “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь” түүх-усаатны зүйн туршиц судалгааны бүтээлдээ “Дэлхийн олон угсаатан ард түмний овгийн түүхнээс үзэхэд, тэдний харилцан холбогдох харь илгэтэн, халуун садангаа ялган мэдэх олон бэлэг тэмдэгтэй байжээ. Жишээлэхэд монголчуудад уг, ураг, удам гарал, овог ястан, махан төрөл, ясан төрөл, гарваль, төрвөл гэж ялган үзэх ёсон тогтож овгийн сүлд, овгийн шүтлэг, ...овгийн тулалдааны уриа хашгираа тус тусдаа байсны гадна овгийн им тамга гэж нэгэн чухал бэлэг тэмдэг байжээ” гээд... монголын түүхийн үе үед олон аймагтан, удамтан оршин суусан бөгөөд, тэд Рашаан хад*, түүний дэргэдэх хадан самбар, тусгай ханан хад, үхэр чулуунд овгийн тамгаа удаа дараагаар сийлж үлдээсэн гэж болно”⁴ хэмээн өгүүлжээ.

Харин тамгыг овгийн бэлэгдэл, бусдаас ялган таних тэмдэг болгон хэрэглэснээс нэлээд хожуу малд дарах болсон байна. Энэ тухай уг бүтээлд “Хүн төмөрлөг багаж, эдлэлтэй болсон цагаас буюу адгуусан амьтан гаршуулах, гэршүүлэх, малжих аж төрөл дэлгэрэхийн хамт, им тамганы тоо олширч, адуусанд улайтган хайрах тамга үзэгдэж эхэлсэн бололтой”⁵ гэжээ. Малын тамга нь монголчуудын өмчийн тэмдэг байсан тухай академич Б.Ринчин доктор 1954 онд “Монголчуудын өмчийн тэмдэг”

³ Е.В. Лупикова. История бухгалтерского учета. Москва. 2006 13-р тал.

⁴ Х.Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. Улаанбаатар. 1965 он. Хуудас 8,25.

⁵ Мөн зохиол 9-р тал.

хэмээх өгүүлэл бичиж Чехсловакийн “Архив Ориентални” сэтгүүлд франц хэлээр нийтлүүлжээ.

Өмчийн тэмдэг болсон малын тамганаас өмнө малыг имнэж тэмдэглэж байсан баримт нь хөрөнгийн нэгэн төрөл тэмдэглээ бөгөөд энэ нь бүртгэл, хяналтын түүхийг тодорхой хугацаагаар урагшлуулж байгаа зүйл гэж үзэх үндэстэй. Дээрхи зохиолд “Монголчуудын малын байнгын дарсан (хайрсан) тамганаас гадна, бас нэгэн сонин байнга тэмдэг байдаг юм. Түүнийг малын им гэдэг. Имийг хайрлага тамганаас өмнө үүсэн гарсан гэж эрдэмтэн нар үзжээ. Им бол овгийн нэн эртний тэмдгийн (тамганы) үлдэц гэдэг нь үнэнтэй хэрэг ажээ”⁶ хэмээн өгүүлжээ.

Эдгээр баримтыг өөрийн эрхэлдэг аж ахуйн өвөрмөц онцлогийг агуулсан агуулахын бүртгэлийн нэгэн төрөл гэж үзэж болох талтай. Тэгвэл манайд бүртгэл, хөрөнгийн хяналт нэлээд эртнээс үүссэн түүхтэй гэж үзэж болохоор байна. Хад чулуунд үлдээсэн энэхүү дүрсүүд нь бүртгэлийн түүхтэй холбоотой гэсэн сонирхолтой тамаглалыг дэвшүүлж тэдгээрийг судлахын чухлыг манай орны бүртгэлийн салбарын зарим эрдэмтэд, тухайлбал Т.Жааваа, Ц.Гунгаанямбуу нар өөрсдийн бүтээлдээ дурьджээ.

Мэргэжлийн үүслийг *нэгдүгээрт*: хэрэв аж ахуйн үйл ажиллагааг зориуд бүртгэж эхэлсэн тэр үеэс тооцвол бүртгэл 6000 жилийн тэртээ үүссэн, *хоёрдугаарт*: нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийг бий болгосон буюу Луко Пачалогийн үеэс тооцвол 500 жилийн тэртээ үүссэн, *гуравдугаарт*: нягтлан бодох бүртгэл нь нэлээд төгс, бие даасан хэлбэрийг олж шинжлэх ухааны хэмжээнд хүрсэн үеэс тооцвол одоогоос 100 жилийн тэртээ үүссэн гэж үздэг⁷.

Үүсэл хөгжлийн явцад бүртгэлийн мэдээллийн технологийг аж ахуйн бүртгэл, нягтлан бодох бүртгэл гэж нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш бөгөөд түүнийг хөгжлийн төвшнөөс нь хамааруулан нэлээд төгс, түгээмэл хэлбэрийг олтол аж ахуйн бүртгэл гэж нэрлэж байжээ. Аж ахуйн бүртгэл нь анх үүсэж бий болохдоо өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааг тоолж бүртгэх, хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэйгээр хэрэглэгдэж байснаа аажимдаа нэлээд төгс хэлбэрийг олсон төдийгүй бүртгэж тайлан гаргах, удирдлагын гол хэрэглүүр болон ашиглагдах болсон тэр үеэс нягтлан бодох бүртгэл гэж нэрлэгдэх болжээ.

Манай орны хувьд аж ахуйн болон нягтлан бодох бүртгэл, хяналт нь анх өртөөний алба, улсын сан хөмрөг, сүм, хийд, жас жавын аж ахуйд нэлээд боловсронгуй хэлбэрийг олсон гэж хэлж болно. Нягтлан бодох бүртгэл үүсэж бий болсон аж ахуйн үйл ажиллагааны үндсэн хэрэгцээний нэг нь өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих явдал байсантай холбоотой гэдгийг дээр өгүүлсэн.

Хүн төрлөхтөн эдийн засгийн үйл явцыг удирдахыг хичээж түүнийг хэрэгжүүлэхэд удирдлагын үндсэн үүрэг болсон хяналт ямагт хамт байсаар ирсэн бөгөөд одоо ч хяналтын үүрэг улам нэмэгдэж байгаагийн жишээ бол хяналт агуулгын хувьд шинэ хэлбэрийг олсоор

⁶ Мөн зохиол 51-р тал.

* Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт дэлхийн газар зүйн 110-р уртраг, 48-р өргөрөгт оршдог.

⁷ А.А.Мазуренко. Зарубежный бухгалтерский учет и аудит. Москва. 2005.

байгаа явдал юм. Энэ талаар бүртгэл, хяналтын үүслийг судалсан эртний дэлхий дахины суут сэтгэгчид, мэргэд тодорхой өгүүлсэн бий. Тухайлбал Платон, Аристотель нар "... эдийн засгийн үндсэн үйл явц, бүхийл механизм нь бүртгэл, хяналтын оролцоогүйгээр байх нь үгүй"⁸ хэмээн үзэж байлаа. Аристотель бүртгэл хяналтын үүргийг маш нарийн зааглан, шалгалт нь хяналтын нэг хэсэг юм гэж үзсэн байдаг. Энэ мэтчлэн эртний суут сэтгэгчид хяналтын талаар "шалгагч бол нягтлан бодогчтой нэгэн ижил эрхтэй байх ёстой ба харин нягтлан бодогч нь шалгагчийн эрхэнд халдах эрхгүй" хэмээн өгүүлсэн байдаг.

Хэрэглэгчийн ашиг сонирхолын өсөлт, нөгөө талаас нягтлан бодох бүртгэл сайжран боловсронгуй болохын хэрээр аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж нэмэгдэн, хяналтын шинэ хэлбэрүүд бий болжээ. Хяналтын хэлбэрүүд өөр хоорондоо ялгаатай бөгөөд юуны өмнө тэдгээрт байдаг нийтлэг шинж нь хяналтыг төрийн болон өмчлөгчийн зүгээс заавал хийх явдал гэж үзэж болох юм.

Төрийн зүгээс тавих хяналтын хэлбэр нь төр үүссэн цагаас бий болсон төрт ёсны үндсэн шинжийн нэг болж байдаг. Үүний зэрэгцээ хяналтын дээрхи хэлбэр нь үлэмж боловсронгуй болсоор төрийн болон төрийн бус, мэргэшсэн байгууллага хүмүүсээр гүйцэтгүүлдэг хяналтын цоо шинэ хэлбэр үүсэж бий болсон нь аудит юм. Хяналтын төрөл бүрийн хэлбэр бий болж, түүнийг эдийн засгийн субъектын удирдлагын үйл ажиллагаанд ашиглах болсноор хяналтын эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх болсон байна.

Шинжлэх ухаан тодорхой салбар болон хуваагдах (дифференциация) үйл явц бий болж байсан тэр үед давхар системийн нягтлан бодох бүртгэлийн талаар анх системтэй ойлголтын үндэс тавигдсан гэж үздэг бөгөөд "нягтлан бодох бүртгэл болон хяналтын шинжлэх ухааны үндэс нь капитализм үүсэж бий болсон тэр цаг үетэй давхцадаг ба бүртгэл хяналт нь капиталист нийгмийн ялалтын үндсийг бүрдүүлэх нэг нөхцөл болж чадсан"⁹ хэмээн барууны судлаачид үздэг.

Нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн зарчим нь маш эрт үндэслэгдсэн бөгөөд харин түүнийг анх удаа Италийн математикч Луко Пачоли хамгийн зохистой байдлаар томъёолсон. Түүний "арифметик болон геометр, харьцаа, хамаарлын тухай сургаалийн цогц" хэмээх бүтээл нь дундат зууны зөвхөн математикийн нээлтүүд агуулаад зогсоогүй аж ахуйн үйл ажиллагааны явцад хяналт тавих бодит хэрэглээ болсон нягтлан бодох бүртгэлийн дансны давхар бичилтийн зарчмыг хамгийн зөв сонгож харуулснаараа нягтлан бодох бүртгэлийн түүхэнд эргэлт хийжээ.

Луко Пачоли "нягтлан бодох бүртгэлийн үндсэн зорилго нь өөрийн үйл ажиллагааг тогтсон журмын дагуу явуулахад ямарч төвөг учруулахгүйгээр төлбөр тооцооны талаар шаардлагатай мэдээллийг олж авч байх боломжийг бүрдүүлж өгөх явдал юм"¹⁰ гэж бичсэн байдаг. Ийнхүү нягтлан бодох бүртгэлийн тухай бичсэн анхны номонд бүртгэл нь төлбөр тооцооны хэмжээг шуурхай тогтоох (бүртгэлийн эрх зүйн орчин),

⁸ А.А. Терехов. Аудит. 12-р тал.

⁹ А.А. Терехов. Аудит. 1999. 13-р тал.

¹⁰ Я.В. Соколов. История развития бухгалтерского учёта. 1985. 46-р тал.

өөрийн үйл ажиллагааны зохистой бүтцийг бий болгох (эдийн засгийн орчин) зорилгоор хөтлөгддөг хэмээн үзсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн харилцан уялдаа бүхий хоёр үндсэн үүргийг илэрхийлж байгаа юм.

XX зууныг хүртэл нягтлан бодох бүртгэл нь цэвэр хяналтын үүрэгтэй байсан бөгөөд үүнийг Италийн судлаач Анжело ди Пиетро "хамгаалах" үүрэг гэсэн байдаг. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн эн тэргүүний үндсэн үүрэг болж байснаа аж ахуйн үйл ажиллагааг удирдахтай холбогдсон үүрэг нь давамгайлж нэгдүгээрт тавигдах болжээ.

Нягтлан бодох бүртгэлийн өмнө тавигдсан үүргийг хэрэгжүүлэхэд бүртгэл хөтлөх арга зүй зайлшгүй болж, бүртгэл хөтлөлттэй холбоотойгоор аж ахуйн үйл ажиллагааг бүртгэх "урлаг"-ийн тухай яригдах болсон байна. Энэхүү уламжлал нь өнөөг хүртэл хадгалагдсаар байгаа ба зах зээлийн орны эрдэмтэд, судлаачид өнөөдөр ч гэсэн нягтлан бодох бүртгэлийг эдийн засгийн шинжлэх ухааны нэг тодорхой салбар гэж үзэхээсээ аж ахуйн үйл ажиллагааг бүртгэх урлаг хэмээн үзсээр байгаа билээ. Дээрхээс үзэхэд нягтлан бодох бүртгэл анх хяналтын эрэлт хэрэгцээний улмаас үүссэн бөгөөд өнөөдөр тэр нь удирдлагын гол хэрэгсэл болон хөгжихдөө мэдээллийг бүрдүүлэх, түүнд үндэслэн хяналтыг хэрэгжүүлэх ач холбогдол нь хэвээр байгаа юм.

Манай орны хувьд аж ахуйн бүртгэл, хяналтыг социалист аж ахуй бүрэлдэн бий болсоноор саяхан үүссэн мэт ойлгох нь буруу бөгөөд түүний үлэмж эртний уламжлалай болох талаар дээр өгүүлсэн. Харин бүртгэл хяналтын зохион байгуулалттай хэлбэр бий болох үндэс суурь, уламжлал нэлээд хожуу үүссэн гэж болно. Өгөөдэй хаан улсын сангаас үгээгүй ядуучуудыг тэтгэх сан, өртөө байгуулж хөрөнгийн зарцуулалтад хатуу хяналт тавьж ажиллахыг зарлиг болгосон тухай "Монголын нууц товчоо"-нд "зуун хониноос нэжгээд хонь гаргаж улсын доторхи үгээгүй ядуучуудын тусламж болгож өгсүгэй.

Бас элч нарыг одоогийн байдлаар явуулахад элч нар удаан явах ба ард олонд зовлон чирэгдэл үлэмж байна. Одоо бид байнга журам болгож зүг зүгийн мянгатаас замчин улаачин гаргаж, суурь суурьд өртөө тавьж элч нарыг ард олны дундуур хамаагүй уургын улаа унаж хэсүүчлэн давхихгүй гагцхүү өртөө замаар явах болгоё. Улааны морь, шүүсний хонь, саалийн гүү, хөллөх үхэр, ачих тэрэг зэргийг тогтоосон хэмжээгээр бэлтгэж, охор шидмэс дутуулбал өрөөлөөр хагас алдалтан болтугай. Халбага хигээс дутуулбал хамар хагас алдалтан болтугай"¹¹ хэмээн өгүүлсэн байдаг.

Хожим манжийн өртөө байгуулагдсан тэр үед энэ тухай "өртөөний занги бичээч нараас өртөөгөөр зорчигчдод нийлүүлсэн гэр, хүнс, уналга, ачлагын морь, тэмээ хичнээн болохыг тодорхойлон тайлан цэс үйлдэж, өөр өөрийн харьяат захиралд улирал тутам болон жилийн эцэст тогтмол мэдээлж байжээ"⁵ хэмээн өгүүлжээ. Тэр үед хөрөнгө зарцуулалтыг нарийн бүртгэж, манж, монгол хэлтэй төв шударга монгол түшмэдээр шалгуулдаг

¹¹ Ц.Насанбалжир. Ар Монголоос Маж Чин улсад залгуулж байсан алба. Улаанбаатар хот. 1964 он. 69-р тал.

байжээ. Эдгээр баримт манайд аж ахуйн хяналт эрт үеэс бий болсныг харуулж байгаа юм.

Манайд нягтлан бодох бүртгэлийн нэлээд боловсронгуй хэлбэрийг анх олсон газрыг сүм хийд, жасын аж ахуй гэж үзэж болно. XIX зууны хоёрдугаар хагсаг Монгол орноор аялж, судалгаа хийсэн Оросын эрдэмтэн, судлаач А.М.Познеевийн бүтээлд энэ талаар олон сонирхолтой зүйл тэмдэглэгдсэн байдаг.

Монголд шарын шашин дэлгэрч, сүм хийд, олноор бий болсон цагаас эхэлж сүм хийдийн аж ахуйд бүртгэл хөтлөхийн зэрэгцээ түүнийг хариуцсан албан тушаалтнууд бий болжээ. Эдгээрийн дотороос сүм хийдийн аж ахуйг эрхэлж, түүний бүртгэлийг хөтөлдөг албан тушаалтан нь нярав байсан ба түүнийг “жасын нярав” хэмээдэг байжээ.

Няраваас гадна “засаг лам” хэмээх албан тушаал байсны дээр түүнийг “..тэр нь сүм хийдийн ажилчдыг ажилд хуваарилах, сүм хийдээс гадуур орших эд хөрөнгө, мал сүрэг, тариалангийн ажилд хяналт тавьж ажиллах үүргийг хүлээнэ”¹² хэмээн өгүүлсэн байдаг. Эндээс үзэхэд эдгээр албан тушаалтан нь аж ахуйн хяналтын үүргийг давхар гүйцэтгэж байсан нь харагдаж байна. Дээр өгүүлсэн баримтууд нь манай оронд бүртгэл, хяналтын биеэ даасан тогтолцоо эртнээс бүрэлдэн бий болж чадаагүйч гэсэн бүртгэл, хяналтын эртний уламжлалтай болохыг харуулж байгаа юм.

1911 онд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялж Монгол орон Манжийн дарлалаас чөлөөлөгдөн анхны 3 яам байгуулсаны нэг нь Сангийн яам байсан бөгөөд, 1921 онд ардын хувьсгал ялж Монгол ардын түр засгийн эрх баригчид, Монгол ардын намын төв хорооны дарга, гишүүдийн хамтарсан хуралдаанаар хоол хүнсний явдлыг сайжруулах, аливаа бараа зүйлийг бүртгэх тухай асуудлыг хэлэлцээд 5 яам байгуулсаны нэг нь мөн Сангийн яам байлаа.

Тус яам байгуулагдсанаар улсын санхүү, бүртгэл, тооцоо, мөнгө зээлийн салбарын үйл ажиллагааг эхлүүлэх, эмхлэн цэгцэлж нэгдсэн тооцоонд оруулах, хяналт тавих талаар дэс дараатай арга хэмжээ авсаны үр дүнд 1927 онд улс оронд санхүүгийн нэгдмэл тогтолцоо бүрдүүлсэн гэж үздэг. 1930 онд хуралдсан МАХН-ын YIII их хурал санхүүгийн хяналт шалгалт сул байгааг тэмдэглээд Сангийн яамны дэргэд санхүүгийн хянан байцаах алба байгуулахаар зөвлөмж өгсөний дагуу Монгол улсын засгийн газрын хуралдаанаас санхүүгийн хяналт шалгалтын алба байгуулахаар шийдвэрлэсний дагуу тус албыг анх байгуулжээ¹³.

1921 онд ардын хувьсгал ялж үндэсний аж үйлдвэр, тээвэр, худалдаа үүссэнээр бүртгэл хяналтын цоо шинэ тогтолцоо бүрэлдэн бий болох үндэс суурь тавигдсан онцлогтой. Монгол оронд тээвэр худалдаа, аж үйлдвэр хөгжиж, орчин цагийн бүртгэл нэвтэрсэнээр нягтлан бодох бүртгэлийн бие даасан систем аажимдаа бүрэлдэн бий болж улмаар бүртгэл хяналтын цоо шинэ тогтолцоо бүрдсэн. 1990-ээд он хүртгэл манайд хяналтын хараат бус хэлбэр байгаагүй бөгөөд улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих болсон тэр цагаас нийгэмд гарсан

¹² А.М.Познеев. Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии в связи с отношениями сего последнего к народу. 1887 г. 87-р тал.

¹³ Монгол улсын санхүүгийн албаны түүх. он. Тал.

өөрчлөлтүүдийн дүнд хяналтын хөндлөнгийн хараат бус хэлбэр бий болох үндэс суурь тавигдсан.

Монгол орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих болсноор нийгмийн амьдралын бүхий л хүрээнд урьдах нийгэмд байгаагүй олон шинэ ойлголт бий болж тэдгээр нь хэдийнээ практик хэрэглээ болж хувирсны нэг нь санхүүгийн хяналтын хөндлөнгийн, хараат бус хяналт юм. Түүхээс үзэхэд манайд бүртгэл, хяналт нэлээд эртний уламжлалтай боловч тэр нь бие даасан систем болон хөгжиж чадаагүй бөгөөд үндсэн шалтгаан нь нүүдлийн мал аж ахуйгаас өөр төвлөрсөн аж ахуй эрхэлж байгаагүй, тэр нь хэтэрхий жижиг байсантай холбоотой гэж болно.

Улс орон бүрт бүртгэл, хяналт үүссэн анхны уг сурвалж нь ойролцоо боловч түүхийн урт удаан хөгжийн явцад тэр нь хэрхэн бүрэлдэн бий болсон, тухайлбал нүүдлийн соёл иргэншилтэй улс орны хувьд ямар онцлогтой, хэрхэн хөгжиж ирснийг түүхийн баримт түшиглэн дорвитой судлах нь нягтлан бодох бүртгэл, хяналтын төдийгүй улс орны соёлын түүхэнд холбогдох үнэт судалгаа болох тул энэ асуудлыг тусгайлан авч үзэх нь зүйтэй. Ер нь бүртгэлийн түүхийн дорвитой судалгаа байхгүйгээс энэ талаар тогтсон ойлголтгүй байгааг ч тэмдэглэхэд илүүдэхгүй.